

## Шатрын бодлого зохиомжийн ОУХМ Г.Лхагвасүрэн агсны нэрэмжит Бодолтын 2009 оны УАШТ-ий дотоод журам

- тэмцээн рапид, блицийн 2009 оны УАШТ-ий завсарлагааны үеэр болно
- тэмцээн нээлттэй (бодлого зохиогчдыг оролцуулахгүй)
- урьдчилж бүртгэхгүй
- хураамжгүй
- тэмцээний даалгаварт хоёр болон гурван нүүдлийн тус бүр 2 бодлого, дөрвөн нүүдлийн бодлого болон хожих этюд тус бүр 1 өгөгдөнө.
- бодох нийт хугацаа 90 минут
- даалгавар нь хүнд хөнгөнөөс хамааран тодорхой оноотой байна.
- даалгавруудын шийдийг зөв олсон, хувилбаруудыг бүрэн заасан зэргийг гол үзүүлэлт болгон оноо өгч дүгнэнэ. **(2 нүүдлийн бодлогод зөвхөн эхний нүүдлийг, 3 нүүдлийн бодлогод эхний нүүдэл түүний зорилго болон харын хамгаалалтад харгалзах цагааны 2-р нүүдлийг зааж бичихэд л хангалттай)**
- оноо тэнцсэн тохиолдолд зарцуулсан хугацааг харгалзана.
- даалгавруудын хариуг тэмцээний хугацаа дуусмагц мэдээллийн самбарт тавина.
- оролцогчид шатар, хариугаа бичих цаас, үзэгтэй байна,
- хариундаа өөрийн овог, нэр, харъяалал, цолыг бичнэ.
- бусадтай хамтрах, ярих ба гарч явахыг хориглоно.
- тэмцээний үеэр гар утсаа салгасан байна.  
*журмын заалтыг зөрчсөн тохиолдол бүрд 0,5 онооны торгууль ноогдуулна.*

Эхний 3 байр эзэлсэн бодогчдыг Аваргын цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн урамшуулал, өргөмжлөлөөр шагнана.

ОУХМ Г.Лхагвасүрэн агсны дурсгалд зориулан бодлого зохиох Олон улсын уралдаан болон Бодолтын 2009 оны УАШТ-ийг түүний хань И.Дуламжав, хүү Л.Мэндбаяр нар санаачлан явуулж байгаа юм.

### Монголын Шатрын Холбоо 2009 оны 5-р сарын 29

#### Товч танилцуулга




#### Баяуд овогт Гомбосүрэнгийн Лхагвасүрэн (1949-2006)

Шатрын бодлого зохиомжийн олон улсын хэмжээний мастер Г.Лхагвасүрэн Дундговь аймгийн Адаацаг суманд төрсөн, инженер-технологич, Хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан цол тэмдэг, Бодолтын УАШТ-ий алт болон хүрэл медальтай. 1980 оноос 100 гаруй бодлого зохион Дэлхийн багийн аварга шалгаруулах 6 тэмцээн болон Болгар, Герман, Итали, Монгол, Нидерланд, Норвег, Орос, Швед зэрэг орнуудад зохиогдсон 40 гаруй уралдаанд оролцохдоо тэмцээн болгонд шагналт буюу үнэлгээт байруудад (эдгээрээс 8 түрүү авсан) шалгарсан, 1986 онд спортын мастер, 2006 онд олон улсын хэмжээний мастер болсон, "Түүвэр

бодлогууд" ном бичиж хэвлүүлсэн. Гурван нүүдлийн мадын төрөлд мэргэшсэн бөгөөд шатрын зохиомжийн шинэлэг механизмыг хайж олох, бусад сэдэв санаатай иж бүрэн байдлаар холбон дээд зэргээр илэрхийлэх, нүүдлийн солигдлыг харуулах зэргээр ажилладаг өвөрмөц арга барилтай, өндөр ур чадвартай зохиогч юм. Түүний зарим бүтээлийг танилцуулъя.

**“Халх гол – 50” олон улсын уралдаанд**  
I шан 1989




# 2 4 ихэр 10+10

Ихрүүд: a/. диаграмм b/.g4 – хар хүү  
c/.b:- e7 хар хүү d/.c:g4 цагаан хүү

- a/. 1. ♖c3 ♗c3/♝c3 2. ♘h3 –A/♞f6 –B #  
b/. 1. ♖d4 ♞d4/♙d4 2. ♞f6 –B/♞g4 –C #  
c/. 1. ♖e4 ♗e4/♝e4 2. ♞g4 –C/♞g6 –D #  
d/. 1. ♖d3 ♞d3/♙d3 2. ♞g6 –D/♘h3 –A #

БТС-ын Хүч нийгэмлэгээс Халхын голын тулалдааны ялалтын 50 жилийн ойд зориулан зохион явуулсан “дүрс сольж ихэр үүсгэх” олон улсын сэдэвт уралдаанд түрүүлсэн энэ бодлогод мадлах нүүдлүүдийн битүү хүрээний (AB+BC+CD+DA) солигдлыг Новотныйн халхлалттай холбон илэрхийлжээ.

**“Чимэдцэрэн-60” уралдаанд**  
I шан 1992



# 3 11+10

1. ♘8h7! (2. ♗e4 ♔d5 3. ♗hf6 #)  
1... ♞f5 2. ♞e6 ♔c7 3. ♗e8 #  
1... ♗f5 2. de ♔c5 3. ♗e3 #

Цагаан бэрс тус бүр гурван дүрсийн (хоёр цагаан, нэг хар) цаанаас буудал хянах шинэлэг санааг Гримшоугийн халхлалттай холбон илэрхийлжээ.

Бодлого зохиох олон улсын уралдааны зарлал нь “Таван цагариг” сонины 2009-01-19 ний №5 болон [www.mongolchess.com](http://www.mongolchess.com) сайт мөн түүнчилэн гадаадын 10 гаруй сэтгүүл, сайтуудад мэдээлэгдсэн болно.

Танилцуулга бичсэн ОУХМ Л.Тогоохүү